

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ДОТООДЫН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Б.Энхжирин

Дотоод хэргийн их сургуулийн докторант, хошууч

Товч агуулга: Энэхүү өгүүлэлээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад Дотоодын цэргийн байгууллагын үүрэг, оролцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, цаашдын чиг хандлагыг тодорхойлохыг зорьлоо.

Abstract: The aim of the study is to analyze the role of and participation of the internal troops in ensuring the national security of Mongolia, current condition and to determine its future trends.

Түлхүүр үгс: Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, үзэл баримтлал, Монгол улсын дотоодын цэрэг, улсын онц чухал объект.

Keywords: National security concept of Mongolia, Internal troops of Mongolia, State critical objects of national importance.

Оршил

Төрөөс Дотоодын цэргийн байгууллагын талаар баримтлах бодлогын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөн”-нд 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр оролцохдоо “Дотоодын цэргийн үүрэг гүйцэтгэх арга, хэлбэрийг боловсронгуй болгох, улс орны аль ч хэсэгт түргэн шуурхай хүрч, онц чухал объектыг хамгаалах, хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх өндөр чадвартай, хөдөлгөөнт хүчин болгон бэхжүүлэх”¹ чиглэл өгсөн нь тус цэргийн цаашдын хөгжлийн чиг хандлагыг гадаадын ижил төстэй чиг

үүрэг бүхий байгууллагуудтай адил түвшинд хүргэх, үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх боломжийг нээж буй томоохон асуудал гэж судлаачийн хувьд үзэж байна.

Иймд энэ чиглэлийн судалгааны ажлыг хөгжүүлж, судлаачдыг судалгааны ажилд татан оролцуулах хэрэгцээ шаардлага нэгэнт бий болжээ.

Нэг. Үндэсний аюулгүй байдлыг хангах байгууллагын чиг үүргийг хуульчилсан байдал

Монгол Улсын үндэсний байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь хэсэгт “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллага” нь “Зэвсэгт хүчин,

¹ Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг сайжруулахад онцгой

анхаарах тухай мэдээлэл (2024).
www.president.mn.

бусад цэрэг”¹, Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Монгол Улсын төрийн цэргийн байгууллын тогтолцоо нь тайван цагт зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагаас бүрдэнэ”², Дотоодын цэргийн тухай хуулийн 3¹ дүгээр зүйлд “Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн” гэж³ тус тус заасан.

Тухайлбал, Дотоодын цэргийн байгууллага нь Улсын онц чухал объектыг хамгаалах, Нийтийн хэв

журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх, Гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох, хуулиар тогтоосон бусад чиг үүргийг гүйцэтгэдэг Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чухал үүрэг бүхий томоохон үр нөлөөтэй төрийн цэргийн байгууллага юм.

Хүснэгт 1. Монгол улсын нутаг дэвсгэрт байгаа дотоодын цэргийн Штаб, анги, тусгай салбарын судалгаа

№	Штаб, анги, тусгай салбар	Объект
Нэг. Улаанбаатар хот		
1.1	Дотоодын цэргийн штаб;	Дотоодын цэргийг удирдах мэргэжлийн төв байгууллага;
	Дотоодын цэргийн дугаар анги;	Улаанбаатар хотын ус хангамжийн эх үүсвэр, ХӨСҮТ, СХЗГ-ын төв байр, Үнэт металлын сорьцын хяналтын газрын байр, НЭМҮТ-ийн төв лаборатори, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын байр;
	Дотоодын цэргийн дугаар анги;	ДЦС-2 ТӨХК, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, Изотоп төв, УМЭАЦТЛ, МҮОНРТ, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар, Гадаадын иргэн, харьяатын газрын төв байр, “Таван толгой түлш” ХХК-ийн үйлдвэрийн I, II, III, IV объект;
	Дотоодын цэргийн дугаар анги;	Дотоод хэргийн их сургуулийн Цагдаагийн сургууль;
	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох;

¹ (Төрийн мэдээлэл. 2002. №3)

² (Төрийн мэдээлэл. 2016. №17)

³ (Төрийн мэдээлэл. 2017. №12)

	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Багахангай дүүргийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Багануур дүүргийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Налайх дүүргийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Хоёр. Орон нутаг		
Архангай		
2.1	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Архангай ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Баян-Өлгий		
2.2	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Цагааннуур чөлөөт худалдааны бүс;
Баянхонгор		
2.3	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Баянхонгор ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж,
Говь-Алтай		
2.4	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Тайширын усан цахилгаан станц, Алтай хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Дархан-Уул		
2.5	Дархан хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Үндэсний дата төвийн нөөц төв; Дарханы дулааны цахилгаан станц;	Дархан хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Үндэсний дата төвийн нөөц төв; Дарханы дулааны цахилгаан станц;
Дорноговь		
2.6	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Дорноговь аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Дорнод		
2.7	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Чойбалсан хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Дорнод бүсийн эрчим хүчний систем;
Орхон		
2.8	Дотоодын цэргийн дугаар анги;	“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ; “Эрдэнэт үйлдвэр” үйлдвэрийн гадна талбай дахь тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, тэсэрч дэлбэрэх бодисын агуулах;
	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Эрдэнэт хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Эрдэнэтийн дулааны цахилгаан станц;
Өвөрхангай		
2.9	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Өвөрхангай аймгийн ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Өмнөговь		
2.10	Дотоодын цэргийн дугаар анги	“Эрдэнэс-Тавантолгой” ХК-ийн Тавантолгой нүүрсний уурхай;
	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;

Ховд		
2.11	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Ховд хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж, Дөргөний усан цахилгаан станц;
Хөвсгөл		
2.12	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Мөрөн хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Хэнтий		
2.13	Дотоодын цэргийн дугаар тусгай салбар;	Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламж;
Булган		
2.14		Дотоодын цэрэг байхгүй
Говьсүмбэр		
2.15		Дотоодын цэрэг байхгүй
Дундговь		
2.16		Дотоодын цэрэг байхгүй
Завхан		
2.17		Дотоодын цэрэг байхгүй
Сүхбаатар		
2.18		Дотоодын цэрэг байхгүй
Сэлэнгэ		
2.19		Дотоодын цэрэг байхгүй
Төв		
2.20		Дотоодын цэрэг байхгүй
Увс		
2.21		Дотоодын цэрэг байхгүй

Хүснэгт 2. Дотоодын цэргийн штаб, анги, тусгай, салбарын байрлал (2024.02.27-ны байдлаар)

Дотоодын цэргийн штаб, анги, тусгай, салбарын байрлалыг харуулав.
(2024.02.27)-ны байдлаар.



Дотоодын цэрэг (2024.03.13)-ны өдрийн байдлаар: Нийслэл хотын хэмжээнд 3 анги, 4 тусгай салбар, Архангай, Баянхонгор, Баян-Өлгий, Говь-Алтай, Дархан-Уул, Дорнод,

Дорноговь, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгуудын хэмжээнд 2 анги, 13 тусгай салбар, тус тус алба-ажиллагаагаа зохион байгуулж

байгаа ба нийт 1 штаб, 5 анги, 17 тусгай салбар байна. Булган, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс нийт 8 аймгуудын нутагт дэвсгэрт Дотоодын цэргийн анги, тусгай салбар байхгүй байна.

Дээрх судалгаанаас үзэхэд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-д заасан объектуудыг хамгаалалтад авч, Дотоодын цэргийн байгууллага өргөжин тэлж байгаа зүй тогтол ажиглагдаж байгаа бөгөөд улсын онц чухал объектыг хамгаалах чиг үүрэг нь дотоодын цэргийн тэргүүлэх чиглэл болж байна. Дотоодын цэргийн үндсэн 6 чиг үүргийн хоорондын уялдаа холбоо, тогтолцоог жигд хөгжүүлэх, нөхцөл бололцоог бүрдүүлэх нь чухал гэж судлаачийн хувьд үзэж байна.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 4 дүгээр зүйлийн 4.2.1 дэх заалтад “Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо” нь “Үндэсний аюулгүй байдлыг хангах үүргийг Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Монгол Улсын Засгийн газар, хууль сахиулах болон тусгай чиг үүрэгтэй байгууллагууд, төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагууд гүйцэтгэнэ” гэж ¹

заасан. Монгол Улсын төр, нийгэм, иргэний аюулгүй байдал харилцан уялдаатай хангагдсанаар Монгол Улсын үндэсний аюулгүй байдал баталгааждаг. Аюулгүй байдлын бодлого цогц байна.

Монгол Улсын "оршин тогтнохуйн аюулгүй байдал", "эдийн засгийн аюулгүй байдал", "дотоод аюулгүй байдал", "хүний аюулгүй байдал", "хүрээлэн байгаа орчны аюулгүй байдал", "мэдээллийн аюулгүй байдал" харилцан уялдаатай хангагдсанаар үндэсний аюулгүй байдал баталгааждаг ба Дотоодын цэргийн байгууллага үүнийг хангахад чухал чиг үүрэгтэй.

Цаашид Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах, Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалахад “Орон нутгийн хамгаалалтын тухай” хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд Дотоодын цэргийн байгууллагын эзлэх байр суурийг тодорхойлж өгөх нь чухал асуудал.

¹ www.legalinfo.mn.

Төрийн цэргийн байгууллын цэргийн мэргэжлийн дээд удирдлагыг Зэвсэгт хүчний Жанжин штаб удирддаг. Зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллага хоорондын нэгдсэн ажиллагааг төлөвлөх, бэлэн байдлыг хангах хамтарсан сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөлтийг батлах, түүний хэрэгжилтэд хяналт тавих, цэргийн байгууллагын зэвсэглэл, техникийн харилцан уялдааг хангах, холбоо мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн удирдлагын цогц үйл ажиллагааг зохион байгуулдаг. Иймд тайван цагт орон нутгийн хамгаалалтын бэлтгэлийг хангах, уламжлалт аюулаас урьдчилан сэргийлэх, уламжлалт бус аюулаас хамгаалах, онц болон дайны байдлын үед орон нутгаа хамгаалах замаар улсыг батлан хамгаалахад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг Дотоодын цэргийн байгууллагын үйл ажиллагаанд хамааруулж авч үзэх нь оновчтой.

Дүгнэлт

Дотоодын цэргийн байгууллагын цаашдын хөгжил, зорилго, зорилт Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байгаа тул иргэд олон нийтийн дэмжлэгийг авч, аюулгүй байдлыг хангах цогц ажиллагааг явуулах нь чухал. Одоогийн дотоодын цэрэг улсын онц чухал объектыг хамгаалах чиг үүргийн хүрээнд хөгжиж, харуул хамгаалалтыг тэргүүлэх чиглэл

болгон ажиллаж байгаа нь Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа дотоодын цэргийн штаб, анги, тусгай салбарын судалгааны үр дүнд нотлогдож байна. Үүнийг дагасан объектын хамгаалалтын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалгах, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах чиг үүргийг гүйцэтгэж буй хамгаалалтын ажилтны хүний нөөцөөс бүрдэж байна.

Цаашид нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюул тохиолдсон үед болон эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг харгалзан хүргэх, террорист үйлдлийг таслан зогсоох тусгай ажиллагаанд оролцох чиг үүрэг бүхий хүний нөөц, сургалтын тогтолцоог бүрдүүлж, Дотоодын цэргийн байгууллагыг хөгжүүлэх нь чухал байна. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргээ Дотоодын цэргийн байгууллага хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд мэдээ, мэдээлэл авах, түүнд суурилсан дүн шинжилгээ хийж, судалгаанд суурилсан аюулгүй байдлын

төлөвлөлт зэрэг арга хэмжээг зохион байгуулах нь ирээдүйд тулгарах сорилт бэрхшээлийг даван туулах арга зам болно. Мөн орон нутгийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийн хүрээнд иргэд олон нийтийн дэмжлэгийг авч ажиллах нь чухал гэж тус судалгааны үр дүнг дүгнэж байна.

Санал

Дэлхийн бусад улс орнуудын жишигт нийцүүлж Дотоодын цэргийн байгууллагын бүтэц, тогтолцоо, чиг үүргийг шинэчлэн тодорхойлж, Үндэсний гвард болгон статус үйл ажиллагааг нь өргөжүүлэх;

Орон нутгийн хамгаалалтын хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулж, Батлан хамгаалах тогтолцооны хүрээнд Дотоодын цэргийн байгууллагын чиг үүргийн тодорхойлох хүрээнд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг оруулах. Мөн Дотоодын цэргийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн Дотоодын цэргийн хууль тогтоомж нь “Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэнэ” гэж заасан хэсэгт “Орон нутгийн хамгаалалтын тухай” хуулийг нэмж оруулах;

Дотоодын цэргийн гэрээт хамгаалалтын тогтолцоог боловсронгуй болгож, шаардлагатай

тохиолдолд иргэдийн хүсэлтээр тэдний аюулгүй байдлыг хангах биечилсэн хамгаалалт зохион байгуулж, тухайн чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг бүрдүүлэх;

Дотоодын цэргийн байгууллагын чиг үүргийг гүйцэтгэх хамгаалалт ажилтныг эргүүл хамгаалалтын офицер удирдах зарчмаар зохион байгуулах цогц ажиллагааг боловсронгуй болгож, цаашид офицер бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр арга тактикийг боловсруулах, объектын аюулгүй байдлыг хангах зорилгоор хамгаалуулагч, улсын онц чухал объектын бүсэд далд хамгаалалт зохион байгуулах;

Галт зэвсэг эзэмшдэг болон хууль бусаар химийн хорт бодис далд зах зээл дээр худалдаалдаг иргэдийн цагдаагийн байгууллагад авагдсан мэдээлэлтэй танилцах эрх бүхий албан тушаалтны хүний нөөцийг бий болгох;

Дотоод цэргийн тухай хуулийн 13.1 дэх заалтад Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор мөн хуулийн 13.1.3-д заасан “гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоох” үүрэг гүйцэтгэхээр заасан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 198 дугаар зүйлд “Нээлттэй хорих анги, 199-р зүйлд хаалттай хорих анги” гэсэн хоёр

дэглэм байхаар заасан тул уг хуульд нийцүүлж Дотоод цэргийн тухай хуулийн 13.1.3-д заасан “нээлттэй, хаалттай хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтоох” үүрэг гүйцэтгэнэ гэж нэмэлт өөрчлөлт оруулах зэрэг саналуудыг дэвшүүлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

- Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын нийгмийн баталгааг

сайжруулахад онцгой анхаарах тухай мэдээлэл (2024) www.president.mn. Татаж үзсэн: 01.17.2024.

- Монгол Улсын үндэсний байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл. 2002. №3.

- Батлан хамгаалах тухай хууль.Төрийн мэдээлэл. 2016. №17

- Дотоодын цэргийн тухай хууль. Төрийн мэдээлэл. 2017. №12

- www.legalinfo.mn.